


ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2015-09 САР)

Монголбанк, “Тэнхлэг зууч” компанитай хамтран 2015 оны 9 дүгээр сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин 5,226 орон сууцны үнийг хамруулсан болно.

ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС


2015 оны 9 дүгээр сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 2.2%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 11.1%-иар тус тус буурчээ.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2013.01=1.00/



Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ орон сууцны үнэ огцом буурсан, мөн хуучин орон сууцны үнийн уналт үргэлжилсэн хэвээр байгаа нь орон сууцны дундаж үнэ буурахад нөлөөлж байна.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ /2013.01=1.00/



2013 оны 1 дүгээр сараас эхлэн орон сууцны үнийн индексийг тооцсон бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр буюу 23.7%-тай гарсан байна. 2014 оны 12 дугаар сараас орон сууцны үнэ (өмнөх оны мөн үетэй харьцуулахад) буурч эхэлсэн бөгөөд 2015 оны 9 дүгээр сарын орон сууцны үнийн жилийн бууралт нь хамгийн доод түвшиндээ буюу -11.1 хувьд хүрчээ.

Жишээ: БГД-ийн “Голден Парк” хотхонд 2014 оны 9 дүгээр сард 1 м² дундаж үнэ 1,957,000 төгрөг байсан бол 2015 оны 9 дүгээр сарын байдлаар 1,729,000 төгрөг болж 11.7%-иар буурсан байна.

1. Шинэ орон сууцны үнэ¹


Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2015 оны 9 дүгээр сарын байдлаар 2,047,000 төгрөг болж өмнөх сараас 1.6%, өнгөрсөн оны мөн үеэс 3.0%-иар буурсан байна.

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2015.09/

Орон сууцны дундаж үнэ	2,047,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-3.0%
Сарын өсөлтийн хувь	-1.6%
Хамгийн өндөр үнэтэй	Хан-Уул
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан


¹ Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон сууц.

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/



Хан-Уул дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/




2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр²

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ³ нь 2015 оны 9 дүгээр сарын байдлаар 88,720,000 төгрөг болж өмнөх сараас 1.9 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 10.9 хувиар тус тус буурсан байна.

ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2015.09/


Орон сууцны дундаж үнэ	88,720,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-10.9%
Сарын өсөлтийн хувь	-1.9%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /сая.төгрөг/



Эх сурвалж: “Тэнхлэг зууч” компанийн сар бүрийн тооцоолол

² Иргэдийн хувьд 2 өрөө байр худалдан авах боломж нь 3-4 өрөө байр худалдан авах боломжоос харьцангуй их.

³ 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)